



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/292

Номгон

Г Иргэн Д.Ганбаатарын эзэмшил газрын  
зөрчлийг арилгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Ганбаатарын 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 3500 м<sup>2</sup> газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул зөрчлийг арилган илүү эзэмшиж буй 63 м<sup>2</sup> газрын үнийг төлүүлэн нэмж эзэмшүүлж хавсралтаар баталсугай.


2. Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт үүрэг болгосугай.

3. Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Д.Ганбаатарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 259 дүгээр захирамжийн хавсралтын ... дэх хэсгийн иргэн Д.Ганбаатарын талбайн хэмжээ хэсгийг хүчингүй болгосугай.

ДАРГА




Д.МӨНХСАЙХАН

142010741



Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны  
өдрийн А/292 дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБAYН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ  
БАЙГАА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Газар эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Зориулалт                    | Хаяг  | Талбайн хэмжээ /м2/ | Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/ | Нийт талбайн хэмжээ |
|-----|-----------------------|-------------------|----------------------|------------------------------|---|---------------------|---|---------------------|
| 1   | Д.Ганбаатар           | ВП72022819        | 040700241            | 5-8 давхар нийтийн орон сууц | Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Таван-Эрдэнийн гудамж-1, 115 тоот | 3500 м2             | 63 м2   | 3563 м2             |

oOo

